Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил Цэцэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн ОНХС-гийн хөрөнгийг батлуулж зарцуулахдаа Сангийн сайдын холбогдох журмуудыг зөрчдөг байдлыг таслан зогсоох, орлогын бүртгэл, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 28-нээс 2021 оны 03 дугаар сарын 31-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга гүйцэтгэв.

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн 1/39 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Цэцэг сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Цэцэг сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Цэцэг сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлог/-ыг сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлогын 7172834.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 71728.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 649693.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 616942.6 мянган төгрөг болж 32751.2 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1: Мөнгөн хөрөнгө

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), (-)	Бууралт	Дүнд эзлэх хувь
ОНХС	493,250.6	416,058.1	(77,192.5)		67.4
СХС	-	23,396.0	23,396.0		3.8
Төрийн сан	156,443.2	177,488.5	21,045.3		28.8
<b>Дүн</b>	<b>649,693.8</b>	<b>616,942.6</b>	<b>(32,751.2)</b>		<b>100</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 616942.6 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө байна.

#### 3.5.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 399358.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 412239.5 мянган төгрөг болж 12880.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	17,284.50	24,783.50	7,499.00
Байгууллагаас авах авлага	108,584.70	130,306.60	21,721.90
Хувь хүмүүсээс авах авлага	90,901.00	88,250.00	(2,651.00)
Зээлийн хүүгийн авлага			-
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	182,588.60	164,372.70	(18,215.90)
Дансны авлага /ОНӨААТҮГ/			-
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/			-
татаас санхүүжилтийн авлага		4,526.70	
<b>Дүн</b>	<b>399,358.80</b>	<b>412,239.50</b>	<b>12,880.70</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 185363.1 мянган төгрөгийн дараах авлага байна.

Нийт авлагын 39.9 хувийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 182588.6 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант зээл олгоогүй 23396.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 164372.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сургууль болон цэцэрлэгийн ажилчидтай холбоотой 20990.4 мянган төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн олон жилийн насжилттай авлага байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлүүдийн хэдэн иргэн нь хугацаа хэтэрсэн, хэдэн иргэний зээл хэвийн төлөлттэй байгаа талаарх мэдээллийг СХС-ийн нягтлан бодогч гаргаж өгөөгүй болно.

Байгууллагаас авах авлага нийт авлагын 31.6 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байгаа нь ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлуудын дутуу гүйцэтгэлтэй ажлын авлага 80908.8 мянган төгрөг, ЗДТГ-ын татаас санхүүжилтийн авлага 38222.8 мянган төгрөг байгаа нь гол нөлөө үзүүлжээ.

Хувь хүнээс авах авлагын эцсийн үлдэгдэл 88250.0 мянган төгрөг байгаа нь малжуулах хөтөлбөрийн авлага 50000.0 мянган төгрөг, хашаа хөтөлбөрийн авлага 27500.0 мянган төгрөг байгаа нь гол нөлөө үзүүлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сургууль болон цэцэрлэгийн ажилчидтай холбоотой авлага 20990.4 сая төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн авлага өглөг үүсгэхгүй ажиллах гэсэн заалттай нийцэхгүй,
- СХС-гийн авлагыг анх үүссэн цагаас нь эхлэн харилцагч нэг бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудын гүйцэтгэл хангалтгүйгээс авлага ихээхэн дүнгээр нэмэгдэж байгаа тул авлагыг барагдуулан ажиллах, сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг эрт эхэлж тайлант онд нь багтаан дуусгах шаардлагатай байна.
- ОНХС-д бүртгэлтэй хувь хүн, байгууллагаас авах 18300.0 мянган төгрөгийн авлага нь олон он дамжсан авлагууд байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 564.4 мянган төгрөг болж өмнөх оноос 31.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3: Урьдчилгаа дансны үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Цалингийн урьдчилгаа	532.8	564.4	31.6
Томилолтын урьдчилгаа			
<b>Дүн</b>	<b>532.8</b>	<b>564.4</b>	<b>31.6</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цалингийн урьдчилгаа дансанд бүртгэлтэй 564.4 мянган төгрөг нь эрүүл мэндийн төв болон ЗДТГ-ын данс бүртгэлд бүртгэлтэй байна. Энэ урьдчилгаа нь материаллаг бус учир дараа онд бүрэн барагдах боломжтой байна.

### 3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 115252.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 186079.8 мянган төгрөг болж 70827.6 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт 4: Бараа материалын үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	6,697.3	6,922.3	225.0
Эм боох материал	3,470.6	11,780.6	8310.0
Бичиг хэргийн материал	43.2	68.2	25.0
Аж ахуйн материал	10,910.0	22,764.6	11854.6
Сэлбэг хэрэгсэл	712.0	390.0	-322.0
Түлш, шатах тослох материал	1,725.9	965.9	-760.0

Барилгын засварын материал	1,650.0	1,650.0	0.0
Хүнсний материал	12,474.5	34,674.1	22199.6
Бусад хангамжийн материал	22,322.3	22,486.7	164.4
Мал амьтад	19,512.0	37,315.0	17803.0
Бэлэн бүтээгдэхүүн	35,734.4	47,062.4	11328.0
<b>Дүн</b>	<b>115252.2</b>	<b>186079.8</b>	<b>70827.6</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал 70827.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 230453.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч үнэ төлбөргүй 31513.6 мянган төгрөгийн бараа материал орлогод авч малын нас дэвшилтийн орлогоор 24015.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 286631.8 мянган төгрөгөөр бараа материал нэмэгдэж 198621.6 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж 16417.0 мянган төгрөгийн малыг нас дэвшүүлсэнтэй холбоотой бууруулсантай холбоотой байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 6989306.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11319760.7 мянган төгрөг болж 4330454.4 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт 5: Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	5,249,240.3	5,997,019.4	747779.1
Тээврийн хэсэгсэл	148,295.3	189,985.3	41690
Машин тоног төхөөрөмж	518,932.1	642,246.0	123313.9
Тавилга эд хогшил зам гүүр	278,715.7	317,227.8	38512.1
Түүх соёлын дурсгалт зүйл	100,200.7	111,270.7	11070
Номын фонд	50,701.1	50,701.1	0
Бусад үндсэн хөрөнгө	562,939.1	597,154.1	34215
Програм хангамж	4,854.0	4,854.0	0
Бусад биет бус хөрөнгө	75,428.0	75,428.0	0
<b>Дүн</b>	<b>6,989,306.30</b>	<b>11,319,760.7</b>	<b>4330454.4</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4750.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандив, хөрөнгө оруулалт, дээд шатны байгууллагаас авсан 4355440.3 мянган төгрөгөөр нэмэгдэж Аймгийн ИТХ-ын тогтоолоор ЭМТ-өөс 29736.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данснаас сургуулийн данс бүргэлд тусгасантай холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

-Хөшөөт багийг нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой “Мо-Эн-Ко” ХХК-ийн хөрөнгөөр хийгдсэн цэцэрлэгийн барилгыг “Хатан түнгэл” ХХК 912606.5 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн боловч данс бүртгэлд тусгаагүй,

-Хөшөөт багын шинэ суурьшлын бүсийн аж ахуйн нэгжийн цахилгаан хангамжийн 10/0.4 кВ 400кВ чадалтай /КТПН/ дэд станц, аж ахуйн нэгжийг холбох, айл өрхийн утсыг хангах барилга угсралтын ажлыг “Гэгээн илч” ХХК 127982.4 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй

- Хөшөөт тосгоны цахилгаан хангамжийн 10кВ-ын ЦДАШ, 250 кВА чадалтай 10/0,4 кВ дэд станц /АТП/ 0.4 кВА-ын ЦДАШ, гэрэлтүүлгийн барилга угсралтын ажлыг “Гэгээн илч” ХХК 194920.5 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

- “Мо-Эн-Ко” ХХК-ийн хөрөнгөөр хийгдсэн Соёлын төвийн барилга, халуун ус, гүнийн худаг, халаалтын зуухны барилга, ус түгээх байр 2, цэвэрлэх байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний байгууламжийг “Алтай трест” ХХК хийж гүйцэтгэсэн боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

- Дээрх барилга байгууламжтай холбоотой газрыг мөн данс бүртгэлд үнэлж бусад биет бус хөрөнгөөр бүртгээгүй байна.

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Манжуур шар гэрлийг байгууллага бүр дээр нь орлогод авах ИТХ-ын тогтоол гарсан боловч 12048.6 мянган төгрөгийн гэрлийг холбогдох байгууллагууд нь орлогод бүртгээгүй байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 49250.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 54377.5 мянган төгрөг болж 5127.5 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт 6: Өр төлбөрийн үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>				
Ажилчидтай холбогдсон өглөг	1,504.9	6,062.0	4,557.1	1
Хувь хүнд төлөх өглөг	1,648.6	1,733.0	84.4	-1
Дансны өглөг /ОНӨААТҮГ/			-	59
Зээлийн хүүгийн өглөг	108.9		(108.9)	1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,573.0	2,254.0	681.0	-1
Байгууллагад төлөх өглөг	44,414.6	44,328.5	(86.1)	61
<b>Нийт дүн</b>	<b>49,250.0</b>	<b>54,377.5</b>	<b>5,127.5</b>	<b>36</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 54377.5 мянган төгрөгийн өр байгаа нь байгууллагад өгөх татаас санхүүжилтийн өглөг 44308.6 мянган төгрөг байгаа нь нийт өглөгийн 81.5 хувийг эзэлж байна. Үлдэгдэл 10068.9 мянган төгрөгийн өр тухайн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр бага дүнтэй байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7094363.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11061331.3 мянган төгрөг болж 3966967.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7: Засгийн газрын хувь оролцоо

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,079,824.1	2,079,824.1	0
Хуримтлагдсан үр дүн	2,918,069.6	6,885,037.0	3966967.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,096,470.2	2,096,470.2	0.0
<b>Дүн</b>	<b>7,094,363.9</b>	<b>11,061,331.3</b>	<b>3,966,967.40</b>

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн данс нь 3966967.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр 3966967.4 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Өмнөх оны хуримтлагдсан үр дүнд 13150.0 мянган төгрөгийн залруулга хийсэн нь сургууль болон ЗДТГ-ын санхүүгийн тайланд хуримтлагдсан элэгдлийн залруулах бичилт хийгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 7172834.8 мянган төгрөг болж өмнөх оноос 1026198.1 мянган төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

Өссөн 1026198.1 мянган төгрөгийн орлогоос материаллаг өөрчлөлт үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1628691.0 мянган төгрөгөөр буюу 61.1 хувиар тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 219683.7 мянган төгрөгөөр буюу 15.3 хувиар, нэмэлт санхүүжилтийн орлого 10502.0 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар, эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилт 9718.0 мянган төгрөгөөр буюу 46 хувиар нэмэгдэж татварын орлого 185143.6 мянган төгрөгөөр буюу 70.6 хувиар, үндсэн үйл ажиллагааны орлого 13200.0 мянган төгрөгөөр буюу 95.6 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 140773.1 мянган төгрөгөөр буюу 42.7 хувиар, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт 503431.4 мянган төгрөгөөр буюу 38.7 хувиар тус тус буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн татварын орлогын биелэлтэд санхүүгийн албаны дарга хяналт тавиагүй хэдэн төгрөгийн орлого орохоос хэдэн төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн талаарх мэдээллийг аудитад гаргаж өгөөгүй болно

### 3.5.11 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 3177490.4 мянган төгрөг болж өмнөх оноос 407784.1 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар буурсан байна.

Буурсан 407784.1 мянган төгрөгийн зардлаас материаллаг өөрчлөлт гарсан дараах зардлууд байна. Үүнд: Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 312320.1 мянган төгрөгөөр буюу 22.7 хувиар, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 40544.9 мянган төгрөгөөр буюу 23.3 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 93458.4 мянган төгрөгөөр буюу 29.6 хувиар тус тус нэмэгдэн тогтмол зардал 1980.4 мянган төгрөгөөр буюу 1 хувиар, хангамж бараа материалын зардал 204396.6 мянган төгрөгөөр буюу 35.9 хувиар, нормативд зардал 7466.2 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар, урсгал засварын зардал 14882.9 мянган төгрөгөөр буюу 76.4 хувиар, томилолтын зардал 8743.4 мянган төгрөгөөр буюу 73.6 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр 47232.1 мянган төгрөгөөр буюу 64.4 хувиар, урсгал шилжүүлэг 6969.1 мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар буурсан байна. Зардал буурах болсон шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна.

Зардлын данстай холбоотой 77286.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

- ОНХС-ийн хөрөнгөөр “Си Би Ай аутсорс” ХХК хийж гүйцэтгэсэн албан байгууллагуудын гаднах шар гэрэлтүүлэг хийсэнтэй холбоотой техник хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зураг төсвийн үнийг суутган аваагүйтэй холбоотой 1211.7 мянга, “Шинэ бүтээлч зам” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 200 м цементэн замын ажилтай холбоотой магадалшгүй ажлын зардлыг суутган аваагүйтэй холбоотой 1135.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- И баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Цэцэг сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 09/02 дугаар тогтоолд Цэцэг сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 94366.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 103679.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт дугаар 8. Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	94,366,000.00	103,679,531.24	(9,313,531.24)
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>94,366,000.00</b>	<b>103,679,531.24</b>	<b>(9,313,531.24)</b>
<b>Татварын орлого</b>	<b>45,661,000.00</b>	<b>77,119,931.24</b>	<b>(31,458,931.24)</b>
<b>Орлогын албан татвар</b>	<b>14,600,000.00</b>	<b>38,393,705.05</b>	<b>(23,793,705.05)</b>
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>14,600,000.00</b>	<b>38,393,705.05</b>	<b>(23,793,705.05)</b>
Үйл ажиллагааны орлого	2,000,000.00	7,756,080.00	(5,756,080.00)
Шууд бус орлого	12,600,000.00	30,637,625.05	(18,037,625.05)
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>24,376,000.00</b>	<b>25,718,850.19</b>	<b>(1,342,850.19)</b>
Бууны албан татвар	2,376,000.00	1,050,000.00	1,326,000.00
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	22,000,000.00	24,668,850.19	(2,668,850.19)
<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>6,685,000.00</b>	<b>13,007,376.00</b>	<b>(6,322,376.00)</b>
<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>4,515,000.00</b>	<b>8,939,851.00</b>	<b>(4,424,851.00)</b>
Улсын тэмдэгтийн хураамж	2,450,000.00	1,671,350.00	778,650.00
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000,000.00	3,825,000.00	(2,825,000.00)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,065,000.00	3,443,501.00	(2,378,501.00)
<b>Газрын төлбөр</b>	-	<b>1,793,925.00</b>	<b>(1,793,925.00)</b>
Газрын төлбөр	-	1,793,925.00	(1,793,925.00)
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>2,170,000.00</b>	<b>2,273,600.00</b>	<b>(103,600.00)</b>
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,070,000.00	1,100,000.00	(30,000.00)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,100,000.00	1,173,600.00	(73,600.00)
<b>Татварын бус орлого</b>	<b>48,705,000.00</b>	<b>26,559,600.00</b>	<b>22,145,400.00</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>48,705,000.00</b>	<b>26,559,600.00</b>	<b>22,145,400.00</b>
Хувьцааны ногдол ашиг	-	-	-
Торгуулийн орлого	5,000,000.00	2,770,000.00	2,230,000.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	43,705,000.00	23,789,600.00	19,915,400.00

Эх сурвалж: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 103679.5 мянган төгрөг буюу 9313.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ. Орлого давсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 23793.7, хөрөнгийн албан татварын орлого 1342.9, бусад татвар, төлбөр хураамж 6322.4, газрын төлбөрийн орлого 1793.9, байгалийн нөөц ашигласны төлбөр 103.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлж төсөвт байгууллагын өөрийн орлого 19915.4, торгуулийн орлого 2230.

мянган төгрөгөөр тасалжээ. Татварын орлого 31458.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлэхэд Эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашгаас хувь хүний орлогын албан татварт 15613.7 мянган төгрөг гол нөлөө үзүүлжээ. Татварын бус орлого 22145.4 мянган төгрөгөөр тасарсан нь торгуулийн орлого 2230.0 мянган төгрөгөөр, СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг тасалсантай холбоотой байна.

### Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3122955.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3122955.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг сая 3122955.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 3122955.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2449744.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 624059.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлийн зардалд 49151.2 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1655400.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүжилтээс, 1191347.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 98699.7 мянган төгрөгийг ОНХС-аас, Эрүүл мэндийн даатгалын сангаас 30850.9 мянган төгрөгийг, 43705.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 102951.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хүснэгт дугаар 9. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	Тайлбар
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт		
1	ЗДТГ	413,287.1	605.0	413,892.1	409,629.6	605.0	410,234.6	(3,657.5)	Төвлөрүүлсэн.
2	ИТХ	51,895.4	-	51,895.4	48,400.2	-	48,400.2	(3,495.2)	Төвлөрүүлсэн.
3	Сум хөгжүүлэх сан		40,000.0	40,000.0		23,396.0	23,396.0	(16,604.0)	СХС зээлийн эргэн төлөлт төлөвлөгдсөн хэмжээнд бүрдээгүй
4	ОНХС	530,259.7	-	530,259.7	271,081.6	-	271,081.6	(259,178.1)	Хөшөөт хөгжил сангаас хөрөнгө дутуу ирсэн
	<b>ОНБ-дын дүн</b>	<b>995,442.2</b>	<b>40,605.0</b>	<b>1,036,047.2</b>	<b>729,111.4</b>	<b>24,001.0</b>	<b>753,112.4</b>	<b>(282,934.8)</b>	
5	ЕБСургууль	992,791.3	600.0	993,391.3	982,472.5	393.6	982,866.1	(10,525.2)	Өөрийн орлогын төлөвлөгөө биелүүлээгүй, төвлөрүүлсэн.
6	Хүүхдийн цэцэрлэг	469,904.7	-	469,904.7	464,391.0	-	464,391.0	(5,513.7)	Төвлөрүүлсэн.
7	Эрүүл мэндийн төв	405,440.2	-	405,440.2	404,523.5		404,523.5	(916.7)	Төвлөрүүлсэн.
8	Соёлын төв	112,720.4	2,500.0	115,220.4	111,488.9	14.9	111,503.8	(3,716.6)	2485.1 мянган төгрөгөөр өөрийн орлого дутуу бүрдүүлсэн, 1115.4 мянган төгрөгийн төвлөрүүлсэн.
	<b>ТЗШ дүн</b>	<b>1,980,856.6</b>	<b>3,100.0</b>	<b>1,983,956.6</b>	<b>1,962,875.9</b>	<b>408.5</b>	<b>1,963,284.4</b>	<b>(20,672.2)</b>	
	<b>Нийт дүн</b>	<b>2,976,298.8</b>	<b>43,705.0</b>	<b>3,020,003.8</b>	<b>2,691,987.3</b>	<b>24,409.5</b>	<b>2,716,396.8</b>	<b>(303,607.0)</b>	

үүсвэр: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 24409.5 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 19295.5 сая төгрөгөөр тасарсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс оруулах орлого, соёлын төв, сургууль нь орлогын төлөвлөгөөг биелээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 49 төсөл, арга хэмжээнд 624059.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 271081.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Дутуу олгогдсон санхүүжилт нь тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хөшөөтийн уурхайн үйл ажиллагаа тасалдсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2770178.4 мянган төгрөг 88.7 хувьтай байгаа нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө, Соёлын төв, сургуулийн өөрийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 30858.6 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/- 92394.8, дээд шатны төсвийн захирагчаас 26181.9 үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5074.9 мянган төгрөг, хандив тусламжийн орлого 1843.0 мянган төгрөг нийт 125494.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт дугаар 10. Нэмэлт санхүүжилт

/мянган төгрөг/

		Бусад орлого	Нийт	
1	ЗДТГ	92,392.5	92,392.5	ОНХС хөрөнгө оруулалт, хүн амын тооллогын зардал СХ
2	Цэцэрлэг	737.2	737.2	ОНХС
	Соёл	1,080.0	1,080.0	Иргэн
3	ЕБСургууль	1,604.2	1,604.2	төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого , БСУГ -аас 500.0 төгрөг
5	ЭМТ	29,680.8	29,680.8	ЭМГ -аас эм бэлдмэлийн үнэ, сорьц тээврийн ажлын хөлс
<b>Нийт дүн</b>		<b>125,494.7</b>	<b>125,494.7</b>	

Эх үүсвэр: Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үүнээс цалин хөлсний зардалд 10239.3 мянга, нормативд зардалд 17882.1 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 1308.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 91412.9 мянга, урсгал шилжүүлэгт 4651.5 мянган төгрөгийг зарцуулжээ.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг байршуулаагүй байна. ОНХС-гийн гүйцэтгэл, СХС-гийн бүх мэдээлэл, ОНХС, СХС-гийн санхүүгийн тайлан, ТТЗ-ийн аудитын тайлан, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэрийг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 196765.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 төлбөрийн актаар 12526.2 мянган төгрөг, 184239.5 мянган төгрөгийн 17 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 7% хэрэгжсэн байна.

Хүснэгт 11 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	12,526.2			1	12,526.2	0%
Албан шаардлага					0	-	0%
Зөвлөмж	17	184,239.5	9	23,449.1	8	160,790.4	13%
<b>Нийт</b>	<b>18</b>	<b>196,765.7</b>	<b>9</b>	<b>23,449.1</b>	<b>9</b>	<b>173,316.6</b>	<b>7%</b>

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн 1 төлбөрийн актын 12526.2 мянган төгрөгийг барагдуулаагүй, 23449.1 мянган төгрөгийн 9 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж 8 зөвлөмжийн 160790.4 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №12. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр		Аудитын дүгнэлт	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Зөрчилгүй	Хязгаарлалттай
1	ЗДТГ	1			1
2	ИТХ		1		
3	Төсвийн шууд захирагч	Сургууль	1	1	
4		Цэцэрлэг	1		1
5		ЭМТ	1		1
6		Соёлын төв	1		1
7	ОНТС	СХС		1	
8		ОНХС		1	
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>4</b>

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-1, “Хязгаарлалттай” 4, нийт 5 дүгнэлт гаргасан байна.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:**

Аудитаар нийт 1268205.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2347.1 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 1265858.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага бичигдэж алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн тайлан байхгүй байна.

### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

ОНХС-гийн хөрөнгөөр “Си Би Ай аутсорс” ХХК хийж гүйцэтгэсэн албан байгууллагуудын гаднах шар гэрэлтүүлэг хийсэнтэй холбоотой техник хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зураг төсвийн үнийг суутган аваагүйтэй холбоотой 1211.7 мянга, “Шинэ бүтээлч зам” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 200 м цементэн замын ажилтай холбоотой магадалшгүй ажлын зардлыг суутган аваагүйтэй холбоотой 1135.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

Хөшөөт багыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотойгоор цэцэрлэгийн барилгыг 912606.5 мянга, цахилгаан хангамж болон гэрэлтүүлэгтэй холбоотой 322902.9 мянга, манжуур шар гэрэлтэй холбоотой 12048.6 мянга нийт 1247558.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, Хөшөөт багт баригдсан Соёлын төвийн барилга, халуун ус, гүний худаг, халаалтын зуухны барилга, ус түгээх байр 2, цэвэрлэх байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний байгууламж, дээрх барилга байгууламж баригдсан газрыг орлогод бүртгээгүй байна. ОНХС-гийн хөрөнгөөр 2018-2019 онуудад хэрэгжүүлсэн 18.3 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

Өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт 7 хувьтай байгаа тул хариуцаж байгаа албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах

Шийдвэрлэсэн нь: Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага бичих

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг байршуулаагүй байна. ОНХС-гийн гүйцэтгэл, СХС-гийн бүх мэдээлэл, ОНХС, СХС-гийн санхүүгийн тайлан, ТТЗ-ийн аудитын тайлан, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэрийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### **Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил**

Цэцэг сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 288629.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 196185.2 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 92444.0 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 6173.7 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 25645.9 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 60624.4 мянган төгрөгийн 13 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 12. ТТЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ	4	59,998.9	1.0	10,000.0	3	49,998.9
2	ИТХ	-	-	-	-	-	-
3	Төсвийн шууд захирагч Сургууль	4	24,467.8	1	16,675.8	3	7,792.0
4	Цэцэрлэг	3	24,027.6	-	-	3	24,027.6
5	ЭМТ	5	160,390.1	1.0	154,476.0	4	5,914.1
6	Соёлын төв	4	19,744.8	1.0	15,033.4	3.0	4,711.4
<b>Дүн</b>		<b>20</b>	<b>288,629.2</b>	<b>4.0</b>	<b>196,185.2</b>	<b>16</b>	<b>92,444.0</b>

№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
		тоо	дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Төсвийн шууд захирагч ЗДТГ	3	49,998.90	-	-	-	-	3	49,998.90
2	ИТХ	0	-	-	-	-	-	-	-
3	Сургууль	3	7,792.00	-	-	1	7,792.0	2	-

4	Цэцэрлэг	3	24,027.60	1	6,173.70	1.00	17,853.90	1	-
5	ЭМТ	4	5,914.10	-				4	5,914
6	Соёлын төв	3	4,711.40	-	-	-	-	3.00	4,711.40
	<b>Дүн</b>	<b>16</b>	<b>92,444.00</b>	<b>1</b>	<b>6173.7</b>	<b>2</b>	<b>25645.9</b>	<b>13</b>	<b>60,624.4</b>

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэл, чанартай холбоотой асуудлыг цаг хугацааны хувьд газар дээр нь очиж үзэж амжаагүй болно.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. СХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: СХС-гийн зээлдэгчийн бүртгэлийг зээлдэгч нэг бүрээр зээл олгосон цагаас нь эхэлж бүртгээгүй, санхүүгийн тайланд бүртгэлтэй авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- 1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, зээлдэгч нар зээл болон зээлийн хүү, алдангийг төлөхгүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг данс бүртгэлд заавал тусгана”, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж СХС анх үүссэн цагаас эхлэн анхан шатны баримт болон дансны хуулгаар зээлдэгч нэг бүрийн тооцоог дахин хянаж баталгаажуулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

##### 2. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

**2.1.1. Илрүүлэлт:** Тайлант онд тус байгууллага нь татварын болон татварын бус орлогыг дансанд орсон мөнгөн дүнгээр нь тайлагнаж санхүүгийн албаны дарга нь өөрийн албан тушаалын тодорхойлолтод заасан зорилтыг хэрэгжүүлээгүй байна.

**2.1.2. Эрсдэл:** Орлогын төлөвлөгөө тасрах, татварын орлого төлөгдөхгүй байх, татвараас зайлсхийх

**2.1.3 Өгсөн зөвлөмж:** Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 42 тоот тогтоолын 2-р хавсралтын 1 дүгээр зорилтын 6-д “Орлогын тогтвортой бааз суурьтай болох судалгаа, мэдээллийн сан бий болгох”, 2-р зорилтын 8-д “Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох байгууллага, албан тушаалтантай тооцоо нийлж...”, 3-р зорилтын хүрээнд “сумын төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор татварын байцаагчийг шуурхай удирдлагаар хангах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН, иргэдтэй тооцоо нийл орлогыг бүрэн оруулахад анхаарч ажиллах.

**2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

### 3. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

**3.1.1. Илрүүлэлт:** Сумын хэмжээнд худалдан авсан бараа бүтээгдэхүүн худалдан авахад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

**3.1.2. Эрсдэл:** Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулахад анхаарч байгууллагын удирдлага, нягтлан бодогч, Төрийн сангийн төлөөлөгч нарыг удирдлагаар ханган ажиллах

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

### 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	Цэцэг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	<b>Аудитын код:</b>
2020			ХОА-2021/15/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Цэцэг сумын Засаг дарга		<b>Мянган төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлаас зураг төсөв, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардлыг суутган аваагүй	2347.1	Төлбөрийн акт		Ж.Мөнхзориг Б.Ариунтуяа
2	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй	0	Албан шаардлага	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	

3	Хөшөөт багын хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, ОНХС-гийн хөрөнгөөр 2018-2019 онуудад хэрэгжүүлсэн ажлын авлагыг бууруулан ажиллаагүй	1265858.0	Албан шаардлага		
4	Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй	0	Албан шаардлага		
5	Санхүүгийн албаны дарга албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй	0	Зөвлөмж өгөх		
6	СХС-гийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй	0	Зөвлөмж өгөх		
7	Анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг санхүүжүүлсэн	0	Зөвлөмж өгөх		
	<b>Дүн</b>	1268205.1			

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР